



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/018/НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025  
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Г.Сугармаа

Утас: 70272287 Цахим хаяг: [sugarmaag@audit.gov.mn](mailto:sugarmaag@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

**АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Э.БОЛОРМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсөвт тодотгол хийснээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 26,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,380,365.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### Аудитын гол асуудал

Төв аймгийн Мөнгөнморьт сум нь 14 нэр төрлийн 1,380,365.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 58 хувь буюу 800,510.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, 579,855.3 мянган төгрөгөөр тасарсан байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл 10 нэр төрлийн орлого 103,261.4 мянган төгрөгөөр давж, 4 нэр төрлийн орлого 696,829.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүний 99,6 хувийг ойн нөөц ашигласны төлбөрийн тасарсан орлого эзэлж байна. Тайлант онд хуш модны самар ургаагүйгээс энэ төрлийн орлого тасрах шалтгаан болжээ.

• 4126020649

#### Бусад асуудлын хэсэг

Мөнгөнморьт сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ нь 8 зорилт, 174 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батламжлагдаж, 76.9 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,647,344.24</b>	<b>1,645,686.49</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,004,801.92	764,222.18
3	1.1.3 АВЛАГА	501,958.27	727,285.78
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	140,584.05	154,178.53
<b>5</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,057,815.07</b>	<b>4,677,040.42</b>
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,057,815.07	4,677,040.42
7	1.2.2.02 Биет хөрөнгө	3,882,937.65	4,542,488.42
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	174,877.42	134,552
<b>9</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>5,705,159.31</b>	<b>6,322,726.91</b>
<b>10</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>33,277.25</b>	<b>735,057.2</b>
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	33,277.25	735,057.2
12	2.1.1.03 Өглөг	33,277.25	735,057.2
<b>13</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,671,882.06</b>	<b>5,587,669.71</b>
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	5,671,882.06	5,587,669.71
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	668,984.84	668,984.84
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	4,802,297.31	4,734,268.33
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,599.92	184,416.54
<b>18</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>5,705,159.31</b>	<b>6,322,726.91</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,804,076.37</b>	<b>2,743,023.84</b>
<b>2</b>	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>703,342.51</b>	<b>770,375.09</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	485,939.79	546,698.14
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	485,939.79	546,698.14
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	26,104.57	27,525.2
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	191,298.15	196,151.75
<b>7</b>	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>120,252.12</b>	<b>1,972,648.76</b>
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0	1,202,414.68
<b>9</b>	<b>1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,980,481.74</b>	<b>0</b>
<b>10</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,361,834</b>	<b>2,499,815.93</b>
<b>11</b>	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,200,717.46</b>	<b>2,347,650.9</b>
<b>12</b>	<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,132,241.28</b>	<b>2,321,400.3</b>
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805,303.82	930,468.78
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,864.95	108,054.13
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	436,785.04	454,141.67
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	49,366.71	53,193.51
17	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	24,299.17	46,159.8
18	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	10,094.5	8,972
19	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,610.6	55,414.97
20	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	686,916.49	664,995.44
<b>21</b>	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,476.19</b>	<b>26,250.6</b>
<b>22</b>	<b>1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>161,116.54</b>	<b>152,165.03</b>
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	442,242.37	243,207.92
<b>24</b>	<b>1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>120,389.46</b>	<b>312,104.87</b>
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-120,389.46	-312,104.87
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	321,852.91	-68,896.95

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	<b>1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,350,029.16</b>	<b>5,350,029.16</b>
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	408.88	408.88
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,350,438.03	5,350,438.03
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-408.88	-408.88
5	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	321,852.91	321,852.91
6	<b>1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,671,882.06</b>	<b>5,671,882.06</b>
7	<b>1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,671,882.06</b>	<b>5,671,882.06</b>
8	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	867.97	867.97
9	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,672,750.04	5,672,750.04
10	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-16,183.38	-16,183.38
11	1.7 Тайлант үеийн үр дүн	-68,896.95	-68,896.95
12	<b>1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,587,669.71</b>	<b>5,587,669.71</b>

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,805,128.54</b>	<b>2,836,136.26</b>
2	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>703,342.51</b>	<b>770,375.09</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	485,939.79	546,698.14
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	26,104.57	27,525.2
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	191,298.15	196,151.75
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,839.69	15,321.25
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	44,985.62	10,041.74
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	135,472.84	170,788.76
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,304.29	2,065,761.17
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	121,304.29	166,567.89
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0	1,202,414.68
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	696,778.6
13	<b>1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,980,481.74</b>	<b>0</b>
14	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,773,371.98</b>	<b>1,917,815.83</b>
15	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,773,371.98</b>	<b>1,917,815.83</b>
16	<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,704,025.8</b>	<b>1,891,359.13</b>
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805,189.16	925,953.38
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,808.42	112,295.64
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,709.86	449,950.52
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	48,454.38	140,696.82
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	44,093.05	1,190
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	120,530.42	87,101.8
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	9,761	9,305.5
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,277.01	50,693.49
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	117,202.5	114,171.99
26	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,346.19</b>	<b>26,456.7</b>
27	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,031,756.55</b>	<b>918,320.43</b>
28	<b>1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>840,592.03</b>	<b>1,077,476.16</b>
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	840,592.03	1,077,476.16
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	840,592.03	1,077,476.16
31	<b>1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-840,592.03</b>	<b>-1,077,476.16</b>
32	<b>1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>16,424</b>	<b>81,424</b>
33	<b>1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-16,424</b>	<b>-81,424</b>
34	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>174,740.53</b>	<b>-240,579.74</b>
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	830,061.39	1,004,801.92
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,004,801.92	764,222.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>3,128,963.0</b>	<b>2,432,138.9</b>	<b>696,824.1</b>	<b>77.7</b>
11	3.1.01.1.1 Татварын орлого	1,374,365.70	770,375.09	603,990.61	56.1
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	469,613.60	546,698.14	-77,084.54	116.4
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	23,650.00	27,525.20	-3,875.20	116.4
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	881,102.10	196,151.75	684,950.35	22.3
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,000.00	15,321.25	-10,321.25	306.4
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	9,697.70	10,041.74	-344.04	103.5
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	866,404.40	170,788.76	695,615.64	19.7
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,754,597.3	1,661,763.81	405,358.13	89.9
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	156,000.00	67,100.71	88,899.29	43.0
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	897,884.5	897,884.5	0	100
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	700,712.80	696,778.60	3,934.20	99.4
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>850,712.8</b>	<b>2,682,370.79</b>	<b>1,309,575.71</b>	<b>67.2</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>-441,233.6</b>	<b>1,814,913.46</b>	<b>885,086.64</b>	<b>67.2</b>
<b>210</b>	<b>3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,655,574.60</b>	<b>1,788,456.76</b>	<b>867,117.84</b>	<b>67.3</b>
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	876,197.90	839,902.38	36,295.52	95.9
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,547.30	102,355.55	10,191.75	90.9
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	452,632.10	437,224.52	15,407.58	96.6
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	50,562.60	35,349.74	15,212.86	69.9
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,190.00	1,190.00	-	100
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	194,949.90	122,278.80	72,671.10	62.7
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	19,872.00	9,305.50	10,566.50	46.8
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,543.60	127,678.29	44,865.31	74.0
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	775,079.20	113,171.99	661,907.21	14.6
<b>213</b>	<b>3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,425.50</b>	<b>26,456.70</b>	<b>17,968.80</b>	<b>59.6</b>
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	44,425.50	26,456.70	17,968.80	59.6
<b>22</b>	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,141,946.40</b>	<b>786,033.32</b>	<b>355,913.08</b>	<b>68.8</b>
<b>23</b>	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>150,000.00</b>	<b>81,424.00</b>	<b>68,576.00</b>	<b>54.3</b>
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	995,436.77		
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	758,438.98		
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	75	20	55	26.7
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	2	1	66.7
62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	36	9	27	25.0
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36	9	27	25.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>438,613.24</b>	<b>582,792.18</b>
<b>12213</b>	Нэмэлт санхүүжилтийн орлого	220,306.60	291,396.09
<b>350013</b>	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	96,742.58
<b>350014</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,201.72	177,019.52
<b>350015</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	57,104.92	17,634.00
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>220,306.64</b>	<b>291,396.09</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>220,306.64</b>	<b>117,368.85</b>
<b>210</b>	<b>1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>161,769.84</b>	<b>117,368.85</b>
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	76,858.08	86,051.00
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,105.14	9,940.09
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,379.89	12,374.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	6,181.39	3,743.76
2107	1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	680.00	-
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,811.03	4,260.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	55,754.32	1,000.00
<b>22</b>	<b>1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>174,027.24</b>
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	-	174,027.24

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1. Залруулсан алдаа:

1. Залруулсан алдаа байхгүй

### 5.2. Залруулаагүй алдаа:

Залруулагдаагүй нийт 696,829.8 мянган төгрөгийн зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 676,879.4 мянган төгрөгөөр их ч шинж чанарын хувьд материаллаг биш гэж үзсэн тул тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 696,829.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн ба 696,829.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

#### 5.2.1. Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2.2. Албан шаардлага

Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Соёлын төв гэх 3 байгууллагыг хариуцсан нягтлан бодогч нь 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар “ажилтан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын суутгал зөрүүтэй, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй зөрчлийг байгууллага тус бүрд гаргаж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд хариуцсан нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

#### 5.2.3 Зөвлөмж

##### 1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 25,103.6 мянган төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогыг 1,432.9 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх 4 нэр төрлийн орлогыг 696,829.8 мянган төгрөгөөр, нийт 723,091.2 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй	7	8				
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Засаг дарга	1	1			1			
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Засаг даргын тамгын газар	1	1				1		
4	Ойн анги	1		1					
5	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
6	Эмийн эргэлтийн сан	1		1					
7	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>5</b>		<b>1</b>	<b>1</b>		

**7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын Тамгын газар	7	959,655.7	2	177,049.3	5	782,606.4	7	959,655.7		
Дүн	7	959,655.7	2	177,049.3	5	782,606.4	7	959,655.7		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	696,829.8					1	696,829.8	1	0
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	3,357.3			1	3,357.3				
Засаг даргын Тамгын газар	7	585,010.4	-	-	4	130,095.5	3	454,914.9		
Хоршоо хөгжүүлэх сан	2				1	219,713.2	1	14,132.4		
Эмийн эргэлтийн сан	1	13,735.1							1	13,735.1
Дүн	13	1,298,932.6			6	353,166.0	5	1,165,877.1	2	13,735.1

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)